ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ӨВА-2023/141/НА-СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: Ж.Нямаа
Утас: 99327992 Цахим хаяг: Nyamaa.audit@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn
Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум
2023 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт ...........................................................................................

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ............................................................

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.......................................................................................................

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .......................................................................

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин......................................................................

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..........................................................

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ......................

4. Аудитын тайлан ...........................................................................................................

4.1 Ерөнхий зүйл .................................................................................................................

4.2 Материаллаг байдал .........................................................................................................

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт...........................................................................

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...................................

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ...............................................

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................................

5. Аудитын илрүүлэлт .....................................................................................................................

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ Т.БАТДЭЛГЭР ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.15 № 67
танай ____________-ны № ____________-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавар дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Зүүнбаян-Улаан сумын эмнэлэг нь оны эхэнд 805334.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлант онд 119688.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 29736.4 мянган төгрөгийн хөрөнгө актлан данснаас хасаж, оны эцэст 895786.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. ЭМЯ, улсын төсвийн хөрөнгө оруулалт, Сумын ЗДТГ, сумын ОНХСан, Дэлхийн Олон улсын энэрлийн байгууллага, Тайваны Хүүхэд гэр бүл дэмжих сангаас нийт 105938,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлого авч , 13750,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно. ЭМД-ын сангаас 71010.0 мянган төгрөгийн санхүүжилтээр өмнөх оны өр авлагыг барагдуулсан.

015030372
D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **138439657.68** | **132988381.48** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 585393.00 | 20570052.80 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 585393.00 | 20570052.80 |
| **3121** | **Төгрөг** | 585393.00 | 20570052.80 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 585393.00 | 20570052.80 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 0.00 | 600000.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 0.00 | 600000.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 0.00 | 600000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 66844264.68 | 111818328.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 45163920.68 | 79277572.68 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3332319.28 | 4995342.28 |
| 35130 | Эм боох материал | 41831601.40 | 74282230.40 |
| **354** | **Хангамжийн материал** | 21680344.00 | 32540756.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14000.00 | 245400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15664895.00 | 19559924.00 |
| 35460 | Хүнсний материал | 4135849.00 | 8494332.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1865600.00 | 4241100.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **599543127.81** | **646507360.76** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 599543127.81 | 646507360.76 |
| **392** | **Биет хөрөнгө** | 578543127.81 | 624157360.76 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 404310648.31 | 404310648.31 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -16206900.64 | -23158134.76 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 55936434.00 | 77190000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -32495004.40 | -22781500.07 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 308911499.83 | 373250035.83 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -152741957.01 | -196810995.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14340751.00 | 17350751.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3857016.67 | -5463332.35 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 344673.39 | 344673.39 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -74785.08 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 21000000.00 | 22350000.00 |
| 39301 | Програм хангамж | 490000.00 | 1840000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -490000.00 | -490000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 21000000.00 | 21000000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **737982785.49** | **779495742.24** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **666972785.49** | **779495742.24** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 666972785.49 | 779495742.24 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 187384660.99 | 187384660.99 |
| 51101 | Өмч: - төрийн | 187384660.99 | 187384660.99 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 203689554.93 | 316212511.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 203689554.93 | 203689554.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 112522956.75 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 275898569.57 | 275898569.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **737982785.49** | **779495742.24** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **551107110.00** | **733736200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **0.00** | **147238900.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0.00 | 147238900.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0.00 | 147238900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | 147238900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **551107110.00** | **586497300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26041500.00 | 27197600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 26041500.00 | 27197600.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 40724710.00 | 559299700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 40724710.00 | 559299700.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **663958903.49** | **614605147.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **663958903.49** | **614605147.63** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 635499854.49 | 613927817.63 |
| 210101 | Үндсэн цалин | 314286265.00 | 330417005.00 |
| 210102 | Нэмэгдэл | 165900448.00 | 204355842.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 95999176.00 | 81794175.00 |
| 210104 | Урамшуулал | 4465000.00 | 4014999.19 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47921641.00 | 40251988.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 40033863.15 | 41707331.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 28166413.36 | 28526000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2966862.57 | 3356000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2373490.07 | 2613356.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 593372.51 | 648546.70 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5933724.64 | 6563427.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 23582451.00 | 25020270.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4154486.00 | 4276539.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19225965.00 | 20743731.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 26226807.00 | 37956636.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1486000.00 | 1640900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16919700.00 | 19279492.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 812280.00 | 786000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 294727.00 | 275100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6714100.00 | 15975144.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 163645782.50 | 89966349.70 |
| 210502 | Хоол, хүнс | 154267981.50 | 81023632.70 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9377801.00 | 8942717.00 |
| 210604 | Урсгал засвар | 11700000.00 | 13625000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11700000.00 | 13625000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 416000.00 | 1263100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 416000.00 | 1263100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1023300.00 | 1908819.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 338300.00 | 93320.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 590000.00 | 1201000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 49000.00 | 200000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 91499.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 46000.00 | 105000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 218000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 54585385.84 | 72063306.73 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 859200.00 | 5947100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 53726185.84 | 66116206.73 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,** | 28459049.00 | 677330.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 459049.00 | 677330.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 459049.00 | 677330.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-112851793.49** | **119131052.37** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 21000.00 | 6608096.32 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 21000.00 | 6608096.32 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -21000.00<br>**-112872793.49** | -6608096.32<br>**112522956.05** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

## Зүүнбаян-Улаан сумын эмнэлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **556300820.00** | **657507300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **551107110.00** | **657507300.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 26041500.00 | 27197600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26041500.00 | 27197600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 40724710.00 | 630309700.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 40724710.00 | 630309700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **545554026.00** | **623772640.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **545554026.00** | **623772640.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **517094977.00** | **623095310.20** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 314286265.00 | 378430218.00 |
| 210101 | Үндсэн цалин | 165900448.00 | 204955842.00 |
| 210102 | Нэмэгдэл | 95999176.00 | 81794175.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4465000.00 | 4014999.19 |
| 210104 | Урамшуулал | 47921641.00 | 87665201.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40033863.15 | 47050621.20 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28166413.36 | 33869290.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2966862.57 | 3356000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2373490.07 | 2613356.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 593372.51 | 648546.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5933724.64 | 6563427.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23582451.00 | 25020270.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4154486.00 | 4276539.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19225965.00 | 20743731.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28452907.00 | 32248285.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1500000.00 | 1872300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16919700.00 | 19279492.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 812280.00 | 786000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 499327.00 | 275100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8721600.00 | 10035393.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 93059790.85 | 113226397.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 77934028.85 | 91585200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12125762.00 | 15041197.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3000000.00 | 6600000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12293000.00 | 15625000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11700000.00 | 15625000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 416000.00 | 1263100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 416000.00 | 1263100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1023300.00 | 1908819.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 338300.00 | 93320.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 590000.00 | 1201000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49000.00 | 200000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 91499.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46000.00 | 105000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 0.00 | 218000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3947400.00 | 8322600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3947400.00 | 8322600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28459049.00** | **677330.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 459049.00 | 677330.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 459049.00 | 677330.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10746794.00** | **33734659.80** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10159400.00** | **13750000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10159400.00** | **13750000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10159400.00 | 13750000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10159400.00 | 13750000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10159400.00** | **-13750000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 587394.00 | 19984659.80 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 585393.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 585393.00 | 20570052.80 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **187,384,660.99** | **275,898,569.57** | **203,689,554.93** | **666,972,785.49** |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **187,384,660.99** | **275,898,569.57** | **203,689,554.93** | **666,972,785.49** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **187,384,660.99** | **275,898,569.57** | **203,689,554.93** | **666,972,785.49** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 112,522,956.75 | 112,522,956.75 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **187,384,660.99** | **275,898,569.57** | **316,212,511.68** | **779,495,742.24** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангил | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 435718600.00 | 434284468.00 | 575567800.00 | 565835310.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 435718600.00 | 434284468.00 | 575567800.00 | 565835310.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 435718600.00 | 434284468.00 | 575567800.00 | 565835310.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 291050000.00 | 291050000.00 | 335600400.00 | 331017005.00 |
| 210101 | Үндсэн цалин | 179452000.00 | 165900448.00 | 212648400.00 | 204955842.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78020000.00 | 90362911.00 | 74799900.00 | 81794175.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6210000.00 | 4465000.00 | 6210000.00 | 4014999.19 |
| 210104 | Урамшуулал | 27368000.00 | 30321641.00 | 41942100.00 | 40251988.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39291800.00 | 39291800.00 | 41950000.00 | 41707331.20 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27649800.00 | 27649800.00 | 28526000.00 | 28526000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2910500.00 | 2910500.00 | 3356000.00 | 3356000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2328400.00 | 2328400.00 | 2684800.00 | 2613356.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 582100.00 | 582100.00 | 671200.00 | 648546.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5821000.00 | 5821000.00 | 6712000.00 | 6563427.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24041500.00 | 23582451.00 | 25697600.00 | 25020270.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3480000.00 | 4154486.00 | 3453900.00 | 4276539.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19755100.00 | 19225965.00 | 20743700.00 | 20743731.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30652900.00 | 30640507.00 | 39061500.00 | 38248285.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1500000.00 | 1500000.00 | 1865500.00 | 1872300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16900000.00 | 16900000.00 | 20064700.00 | 19279492.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 824000.00 | 812280.00 | 758400.00 | 786000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500000.00 | 499327.00 | 275100.00 | 275100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10928900.00 | 10928900.00 | 16035400.00 | 16035393.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34381900.00 | 34111910.00 | 96972900.00 | 96972900.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22881900.00 | 22611910.00 | 77071700.00 | 77071700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8500000.00 | 8500000.00 | 13301200.00 | 13301200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3000000.00 | 3000000.00 | 6600000.00 | 6600000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6392500.00 | 6392500.00 | 21525000.00 | 21375000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4392500.00 | 4392500.00 | 7750000.00 | 7750000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2000000.00 | 2000000.00 | 13625000.00 | 13625000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 665000.00 | 92000.00 | 1550000.00 | 1263100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 665000.00 | 92000.00 | 1550000.00 | 1263100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1143000.00 | 1023300.00 | 2007100.00 | 1908819.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450000.00 | 338300.00 | 112500.00 | 93320.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 590000.00 | 590000.00 | 1201000.00 | 1201000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 49000.00 | 49000.00 | 200000.00 | 200000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 8000.00 | 0.00 | 105000.00 | 91499.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46000.00 | 46000.00 | 153600.00 | 105000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | | 235000.00 | 218000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8100000.00 | 8100000.00 | 11203300.00 | 8322600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8100000.00 | 8100000.00 | 11203300.00 | 8322600.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 435718600.00 | 434869861.00 | 575567800.00 | 586497300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 26041500.00 | 26041500.00 | 27197600.00 | 27197600.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 26041500.00 | 26041500.00 | 27197600.00 | 27197600.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 409677100.00 | 408828361.00 | 548370200.00 | 559299700.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 409677100.00 | 408828361.00 | 548370200.00 | 559299700.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.00 | 585393.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 585393.00 | 0.00 | 20570052.80 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 21.00 | 23.00 | 21.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 13.00 | 15.00 | 13.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | 7.00 | 7.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **71010000.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **71010000.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 71010000.00 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 47413213.00 |
| 210104 | Урамшуулал | 47,413,213.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5343290.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,343,290.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 16253497.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 14,513,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,739,997.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2000000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 71010000.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 71010000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 71010000.00 |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнбаян-Улаан сумын эмнэлэг нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.”Сум, тосгоны эрүүл мэндийн төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна” гэж заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2.эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах; 6.1.3.харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх; 6.1.5.сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн заалтаар чиг үүргээ гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41.5 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 585.4 | 20570.0 | 19984.6 |
| Авлага | 71010.0 | | -71010.0 |
| Бараа материал | 66844.3 | 111818.3 | 44974.0 |
| Үндсэн хөрөнгө | 599543.1 | 646507.4 | 46964.3 |
| **Нийт хөрөнгө** | **737982.8** | **779495.7** | **41512.9** |
| Өр төлбөр | 71010.0 | | -71010.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 666972.8 | 779495.7 | 112522.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **737982.8** | **779495.7** | **41512.9** |

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс өссөн шалтгаан нь: ЭМЯ, улсын төсвийн хөрөнгө оруулалт, Сумын ЗДТГ, сумын ОНХСан, Дэзэрэт Олон улсын энэрлийн байгууллага, Тайваны Хүүхэд гэр бүл дэмжих сангаас нийт 105.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлого авч , 13.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн анх зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМД-аас 550.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 27.2 сая төгрөг төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1.7 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр ЭМД-аас 548.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 27.2 сая төгрөгийг баталсан.

Гүйцэтгэлээр ЭМД-аас 559.3 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 27.2 сая төгрөгөөр санхүүжигдэж 0.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. гүйцэтгэлийн санхүүжилтээр 10.9 сая төгрөгийн санхүүжилт нэмж орж ирсэн нь харилцах дансанд зарцуулагдаагүй үлдсэн. Төсвийн харилцах дансанд 20.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 565.8 сая төгрөг буюу 96.5 хувьтай зарцуулагдсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 27197.6 | 26520.3 | 677.3 | 97.5 |
| 2 | 80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 313959.2 | 310921.6 | 3037.6 | 99.0 |
| 3 | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 199372.2 | 205843.0 | -6470.8 | 103.2 |
| 4 | 83603-Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан | 22550.4 | 22550.4 | 0 | 100 |
| | Дүн | 563079.4 | 565835.3 | -2755.9 | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тус байгууллагын хувьд нэмэлт төсвийн санхүүжилтийн тайланд өмнөх оны ЭМД-аас авах авлага, өр төлбөрөөр бүртгэсэн санхүүжилтийг тайлагнасан.

#### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус байгууллагад төсөл, хөтөлбөр арга хэмжээ хэрэгжээгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны 2 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Элбэгбаян-Булаг" аудит ХХК-ын аудитор Ж.Нямаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнбаян-Улаан сумын эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Элбэгбаян-Булаг" аудит ХХК-нд 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 80 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 614.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.

Энэ хуулийн хүрээнд зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзсэн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын хувьд завсрын аудит хийгдээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | |
| Зөвлөмж | | 0 | 0 | 0 | |
| **Нийт дүн** | 0 | 0 | 0 | 0 | |

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа , зөрчил илрээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

### 5.2 Албан шаардлага

Тус байгууллагад албан шаардлага хүргүүлээгүй.

### 5.3 Зөвлөмж

Тус байгууллага зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Буруу тусган | Үнээс | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|

| | | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | илэрхийлсэн | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | 0 | 0 | | | 0 | 0 | 0 | 0 | | | | |
| Дүн | 0 | 0 | | | 0 | 0 | 0 | 0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | | | | |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил илрээгүй .

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР